

**"ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ҮНДЭСНИЙ  
ЧУУЛГАН"-ААС ГАРГАСАН ЗӨВЛӨМЖ**

2023 оны 05 дугаар  
сарын 18-ны өдөр

Төрийн ордон

"ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ҮНДЭСНИЙ ЧУУЛГАН-  
II"-д төрийн болон төрийн бус байгууллагууд, олон улсын байгууллагууд, ажилтан,  
ажил олгогч, аж ахуйн нэгж байгууллагыг төлөөлөн оролцсон төлөөлөгчид **БИД**:

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн өнөөгийн байдал, тулгамдаж буй  
асуудал, ажилтан, ажил олгогчийн эрх, үүрэг, оролцоо, орон нутаг болон зам тээвэр,  
уул уурхай, барилгын салбар дахь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн  
талаарх бодлого үйл ажиллагаа, мэргэжлээс шалтгаалсан өвчний оношлогоо,  
эмчилгээ, урьдчилан сэргийлэлт, хяналт, удирдлагын тогтолцоо, олон улсын сайн  
туршлага, сургамжийн талаар хэлэлцэж,

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль эрх зүйн орчин  
боловсронгуй болж, бүтэц, тогтолцоо бүрэлдэн бий болсон зэрэг томоохон ахиц  
дэвшилд хүрснийг онцлон тэмдэглэж,

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан  
сэргийлэхэд салбарын яам, орон нутаг, МҮЭХ, МАОЭНХ ХАБЭМТөв, аж ахуйн нэгж,  
байгууллага хамтран харилцан уялдаа холбоотой ажиллахын чухлыг хүлээн  
зөвшөөрч,

Ажил хөдөлмөр эрхэлж буй хүн бүр хөдөлмөрийн эрүүл, аюулгүй орчинд  
ажиллаж, өөрийгөө болон бусдыг аюул эрсдэлээс хамгаалах, аюулгүй ажиллах зөв  
дадал хандлагыг төлөвшүүлэхийг чухалчилж,

Монгол Улсын Засгийн газар, төрийн бүх шатны байгууллага, өмчийн бүх  
хэлбэрийн аж ахуйн нэгж байгууллага, хөдөлмөр, нийгмийн зөвшлийн талууд, нийт  
ажилтан, ажил олгогч, ард иргэддээ хандан дараах **ЗӨВЛӨМЖИЙГ** гаргав.

**Нэг. Хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох талаар:**

1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийг шинэчлэн батлуулах  
ажлын хэсэгт Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хөдөлмөрийн аюулгүй  
байдал, эрүүл ахуйн үндэсний хороо, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл  
мэндийн төв, Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо, Монголын ажил олгогч  
эздийн нэгдсэн холбоо, аж ахуйн нэгж байгууллагууд харилцан уялдаа холбоотой  
ажиллах,

2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн 2021-2025 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллах,
3. Олон Улсын Хөдөлмөрийн байгууллагын Аж үйлдвэр, худалдаан дахь хөдөлмөрийн хяналтын тухай 81, Хөдөө аж ахуй дахь хөдөлмөрийн хяналтын тухай 129 дүгээр конвенцод Монгол Улс нэгдэн орох эсэх асуудлыг судлан шийдвэрлэх,
4. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 26.2 дахь хэсэг “Төсвийн байгууллага нь тухайн жилийн батлагдсан төсвийн 0.5 хувиас, аж ахуйн нэгж, байгууллага эрсдэлийн түвшингээс хамааран үйлдвэрлэл, үйлчилгээний зардлын 1.5 хувиас доошгүй хэмжээний хөрөнгийг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд тус тус зарцуулна.” гэсний хэрэгжилтийг хангах, тус хөрөнгийг Сангийн яам 2024 оноос эхлэн төсвийн байгууллагуудын төсөвт тусгуулах замаар шийдвэрлүүлэхийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас хариуцан ажиллах,
5. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай болон холбогдох бусад хууль тогтоомж, стандарт шаардлагыг хангаагүй аж ахуйн нэгж байгууллага, албан тушаалтанд ногдуулах хариуцлагыг нэмэгдүүлэх асуудлаар санал боловсруулж, шийдвэрлэх,
6. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг санхүүжүүлэх журмыг шинэчлэн сайжруулах,
7. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2019 оны “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт зохион байгуулах тухай” А/370 журмыг шинэчлэн боловсруулж, сургалтын байгууллагуудыг сургалтын чанар, хүртээмжийг дээшлүүлэн, өрсөлдөх, төрөлжих боломжийг нэмэгдүүлэх,

**Хоёр. Мэргэжлээс шалтгаалсан өвчин, үйлдвэрлэлийн осол, хурц хордлогоос урьдчилан сэргийлэх талаар:**

1. Аймаг, нийслэл, дүүрэг, сум дундын эмнэлгүүдэд мэргэжлээс шалтгаалсан өвчний анхан шатны үзлэг хийх нөхцөлийг бүрдүүлэх, холбогдох тоног төхөөрөмж, хүний нөөцөөр хангах, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвар алдсан иргэдэд зориулсан нөхөн сэргээх кабинет ажиллуулах,
2. Мэргэжлээс шалтгаалсан өвчнийг оношлох, эмчлэх, ажилтнуудын хөдөлмөрийн чадвар алдалтыг нөхөн сэргээх, сувилах чиг үүрэг бүхий мэргэжлээс шалтгаалсан өвчин судлалын эмнэлгийн барилга шинээр баригдаж байгаатай холбогдуулан орчин үеийн тоног төхөөрөмж, багаж техник хэрэгслээр хангах, эмч эмнэлгийн мэргэжилтнүүдийн орон тоог нэмэгдүүлэх, тэднийг чадавхжуулах,

3. Мэргэжлээс шалтгаалсан өвчтөнийг эмчлэх, хөдөлмөрийн чадвар алдалтыг нөхөн сэргээх, сувилах чиг үүрэг бүхий сувиллын барилгыг шинээр барих санхүүжилтийг шийдвэрлэх,
4. Аж ахуйн нэгж, байгууллага бүр осол дөхсөн тохиолдол бүрийг судлан бүртгэж, мэдээллийн цахим сан бий болгох, хариуцлагажуулах, хяналтын байгууллагад тухай бүр мэдээлэх,
5. Аж ахуйн нэгж, байгууллагууд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлагын тогтолцооны стандартыг нэвтрүүлэх,
6. Хяналтын байгууллага салбарын яамдад шилжиж ирсэнтэй холбогдуулан шилжилтийн үеийн төлөвлөгөөг боловсруулж ажиллах, салбарын /хөдөлмөрийн/ хяналтын болон хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, орон нутаг дахь хөдөлмөрийн хяналтыг сайжруулах

#### **Гурав. Бусад асуудлын талаар:**

1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар хороо, орон нутгийн зөвлөлийн үйл ажиллагааг идэвхжүүлэх,
2. Түншлэгч талууд уялдаа холбоог сайжруулах,
3. Ажлын байрны нөхцөлийн түүвэр судалгаа, үйлдвэрлэлийн осол, гэмтэл, мэргэжлээс шалтгаалсан өвчлөлийн улмаас учрах нийгэм, эдийн засгийн нөлөөллийн судалгааны ажлыг зохион байгуулах,
4. Эрсдэл өндөртэй салбарууд болох Уул уурхай, зам тээвэр, барилга, эрчим хүчний салбаруудаас гадна Боловсрол, эрүүл мэнд, хөдөө аж ахуй зэрэг ажиллах хүч ихээр шаарддаг салбаруудад тохирсон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар бодлого, үйл ажиллагаа боловсруулж хэрэгжүүлэх,
5. Улсын хэмжээнд аюул, осол, эрсдэлийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх, сурталчилах талаар үйл ажиллагаа тогтмол зохион байгуулах,
6. Ажилтныг олон улсын стандартад нийцсэн ажлын хувцас, тусгай хамгаалах хэрэгслээр хангах үйлдвэрлэл, үйлчилгээ бий болгох, энэ чиглэлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгж, байгууллагыг дэмжлэх,

Зөвлөмжийг хэрэгжүүлэх хүрээнд холбогдох байгууллагууд ажлын хэсэг байгуулан, хэрэгжилтийг ханган, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний хороогоор хэлэлцүүлэхээр шийдвэрлэв.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чуулганы төлөөлөгчид

2023 оны 05 дугаар сарын 18-ны өдөр